



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/407

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Рашаант дарцагт” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Хуучин 1, 2, 3, 4-30 айлын орон сууцны барилгын гадна фасадны засварын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Туулайтулга - Жаргалант сумын Засаг даргын орлогч

Гишүүд: Д.Нямтулга - Мэргэжлийн хяналтын газрын Барилгын техникийн хяналтын улсын байцаагч

Б.Түмэндэмбэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

З.Өмиртай - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

Г.Цэдэнбал - Монгол Улсын Гавьяат барилгачин

Г.Баатарболд - Хөндлөнгийн орон тооны бус ажлын хэсгийн гишүүн

Д.Цогтхүү - Стандарт хэмжил зүйн хэлтсийн байцаагч

М.Мөнхцэцэг - Жаргалант сумын Жаргалан багийн Засаг дарга

Д.Бурмаа - “Оргил” сууц өмчлөгчдийн холбооны байцаагч

Д.Галя - 4-30 айлын оршин суугчдын төлөөлөл

- Б.Бурмаа - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
С.Батдорж - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль,
эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга
- Б.Гантоого - “Рашаант дарцагт” ХХК-ийн захирал
- Нарийн бичгийн
дарга: Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын мэргэжилтэн

2. “Рашаант дарцагт” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Туулайтулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН